

БАТЛАВ:

“ЭРДЭНЭГ ҮЙЛДВЭР” ТӨҮГ-ЫН  
ҮЙЛДВЭРЛЭЛТ ТЕХНИКИЙН  
БОДЛОГЫН ГАЗРЫН ДАРГА  
..... П.БАТБОЛОР  
20... оны ... сарын ...-ны өдөр

ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ ХИЙХ  
ТЕХНИКИЙН ДААЛГАВАР

1. **ЗАХИАЛАГЧ:** ГЕОЛОГИ ХАЙГУУЛЫН ЭКСПЕДИЦИ

2. **ТЕХНИК, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ТОДОРХОЙЛОЛТ:**

ШАТАХУУН ТҮГЭЭХ СТАНЦЫН ЗАСВАРЫН АЖЛЫН ЗУРАГ, ТӨСӨВ

3. **ЗУРАГ, ТӨСӨВ ХИЙХ НӨХЦӨЛ, ШААРДЛАГА:**

- Байгууллагын дотоод хэрэгцээний ШТС нь аж ахуйн нэгжийн эдэлбэр газар дахь авто замын зорчих хэсгийн зах хүртэл 5м, буулгах талбай хүртэл 9м зайтай байна гэсэн БНБД 21-07-14-ийн Хавсралт Б, тавдугаар хүснэгтийн 6 дахь заалтыг мөрдөх.
- ШТС-ын эзэмшлийн талбай дахь тээврийн хэрэгслийн хөдөлгөөн нь нэг чиглэлтэй байх, орц ба гарцыг тодорхой тогтоосон байна /БНБД 21-07-14-ийн 5.13 заалт/. Байршуулах тэмдэг, тэмдэглэгээ нь MNS4643:1998 стандартын шаардлага хангасан байна.
- Тээврийн хэрэгсэл нь түгээх талбайгаас шууд гарах нөхцөлийг бүрдүүлсэн байх /БНБД 21-07-14-ийн 6.18 заалт/.
- ШТС-ын буулгах /автоцистерн зогсох/ талбай нь 150 мм-ээс багагүй өндөртэй хашлагаар хүрээлэгдсэн байх бөгөөд автоцистерний буулгах хоолойн битүүмжлэл алдагдахад буулгах талбайд асгарсан шатахууныг буулгах талбайгаас гадагш тархаахгүйгээр ослын нөөц сав руу юүлэх боломжийг хангасан байх /БНБД 21-07-14-ийн 6.17 заалт/.
- ШТС-ын буулгах талбайд автоцистерн орох ба гарахад аюулгүй байдлыг хангахад зориулсан пандус төлөвлөх /БНБД 21-07-14-ийн 6.17 заалт/.
- ШТС нь чанга ярих хэрэгсэлтэй байна /БНБД 21-07-14-ийн 6.25 заалт/.
- Цахилгааны шугам, утсыг инженерийн шугам сүлжээ, утааны яндан, халуун усны хоолойтой зэрэгцүүлэн ил, далд байдлаар татаж ашиглахыг хориглоно

/ГАБҮД 4.10 заалт/.

- Шатахуун түгээх станцаас 200 метрээс ихгүй зайд 100 м3-ээс багагүй багтаамжтай усны нөөц эсвэл 2-оос цөөнгүй галын гидрант байна гэсэн БНБД 21-07-14-ийн 10.2 заалтын шаардлагыг хангаж байнгын ажиллагаатай галын гидрант байрлуулах зэрэг ажлуудыг зурагт тусган төсөв хийх.

#### 4. ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ХЭМЖЭЭ, АЖИЛБАРУУД:

- Байгууллагын дотоод хэрэгцээний ШТС-д баримтлах дүрэм, норм, стандартын шаардлагуудын дагуу зураг төсөв боловсруулах,
- ШТС-ын эдэлбэр газрын хил хүрээг тогтоож, тусгаарлах хаалт хашилтыг холбогдох хууль, дүрэм, норм, стандартын дагуу төлөвлөх,
- Түгээх талбайн орц гарцыг зааж, стандарт тэмдэг тэмдэглэгээ байршил төлөвлөх,
- Буулгах талбайг дүрэм, нормын шаардлагуудыг ханган зурагт оруулах,
- Шатах тослох материалын агуулахад чанга ярих хэрэгслийн холболтыг төлөвлөх,
- Шатах тослох материалын агуулахад халаалтын шугам цахилгааны шугамтай хамт орсон байгааг салгаж дүрмийн дагуу угсрах ажлыг төлөвлөх.

#### 5. ГҮЙЦЭТГЭГЧИД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

- MNS 4628:2013 Стандартыг баримтлан зураг, төсөв боловсруулж,эксперт хийлгэсэн байх.
- Зураг, төсөвт Гал түймрийн улсын байцаагчийн 2024.03.27 ны №01/126 тоот албан шаардлагад тусгасан шаардлагууд зурагт хийгдсэн байх.

#### 6. АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ХУГАЦАА: Гэрээнд заасан хугацаанд хийж гүйцэтгэх.

#### 7. АЖИЛ ГҮЙЦЭТГЭГЧИЙН БАТАЛГАА:

- Эксперт хийлгэсэн, Гал түймрийн улсын хяналтын байцаагчаар хянагдсан байх.

#### ЗӨВШӨӨРӨВ:

ҮЙЛДВЭРЛЭЛ,ТЕХНИКИЙН

ХЭЛТСИЙН ТЕХНИКИЙН АЛБАНЫ ДАРГА


#### ХЯНАСАН:

МЕХАНИКИЙН ХЭЛТСИЙН ДАРГА-ЕРӨНХИЙ МЕХАНИК


ГХЭ-Н ДАРГА

#### БОЛОВСРУУЛСАН:

ГХЭ-ИЙН АХЛАХ МЕХАНИК



Б.МӨНХНАСАН



Б.ЧИНЗОРИГ  
М.ДАМДИНСҮРЭН



Х.ЭРДЭНЭБИЛЭГ